

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

**Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:** Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж, 12 асуудал хэлэлцэж, аймгийн 2019 оны төсвийн тодотголын тухай, газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Алтан Хөхий уулын байгалийн нөөц газрын газар нутгийн хэмжээг өргөтгөж, байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авах тухай, Баатарын нурууг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай, Ховд аймгийн Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөний төслийн тухай хэлэлцэж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар, аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөөний төсөл, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын төсөл, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцэж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 13 өргөдөл бичгээр хүлээн авч, 13 өргөдлийг шийдвэрлэсэн, аймгийн Засаг даргын Тамгын газарт 9 өргөдөл бичгээр хүлээн авч, 6 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэх шатандаа хүлээгдэж байна.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 1 өргөдөл бичгээр хүлээн авсан, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 82.6 хувийн шийдвэрлэлттэй байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 2 сувгаар 27 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 25, биечлэн 2 санал хүсэлт ирүүлснээс гомдол 6, санал хүсэлт 19, шүүмжлэл 2 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 24 иргэний санал хүсэлтэд хариу өгч шийдвэрлэлт 88.9 хувьтай байна. Үүнд: боловсролын асуудлаар 1, эрүүл мэндийн асуудлаар 2, орчны эрүүл ахуйн асуудлаар 8, хууль эрх зүй 3, цахилгааны асуудлаар 1, бусад асуудлаар 12 иргэн тус тус хандсан.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 14 төрлийн үйлчилгээгээр 565 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 2439 иргэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 1 байцаагч 2 төрлийн үйлчилгээгээр 378 иргэнд нийт 6 мэргэжилтэн 31 төрлийн үйлчилгээгээр 3382 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллав.

**Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын 6 дугаар сард улсын төсвөөс авах урсгал санхүүжилт 31951.8 сая төгрөг бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардал, ОНХС-ийн зардлуудыг хянаж, батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олголоо.

Сумдад санхүүгийн дэмжлэг 5542.9 сая төгрөг, аймгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн байгууллагуудад 3681.0 сая төгрөг, халамжийн санд 114.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт

сургууль 13542.5 сая төгрөг, цэцэрлэг 5982.1 сая төгрөг, хүн эмнэлэг 2741.6 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 200.8 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 146.9 сая төгрөг тус тус олгосон.

Орон нутгийн төсвийн 154 байгууллага, төсөл сангийн 36, ОНӨААТҮГ-ын 8 нийт 198 байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсныг хүлээн авч хянан “Е” цахим тайлангаар нэгтгэж Сангийн яаманд хянуулж баталгаажууллаа.

Аймгийн төрийн аудитын газраас 137 төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тайлангийн аудит хийхэд 7 байгууллагад “Итгэл” үзүүлж, 79 байгууллага “Зөрчилгүй”, 47 байгууллага “Хязгаарлалттай”, 3 байгууллагад “Сөрөг”, 1 байгууллагад “Татгалзсан” дүгнэлт өгсөний дагуу аудитын зөвлөмж, акт, албан шаардлагуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

Тайлан тушаалтаар аймгийн Засаг даргын 2015 оны “Санхүүгийн ажилтнуудын ажил дүгнэх үзүүлэлт батлах тухай” А/236 дугаар захирамжийн дагуу нийт 140 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг 14 үзүүлэлтээр дүгнэхэд ажлын үнэлгээний дундаж аймгийн дүнгээр 84,6 хувьтай, хөдөөгийн 16 сумдын дундаж үнэлгээ 79,6 хувь, Жаргалант сумын үнэлгээ 88.3 хувь, аймгийн төвийн байгууллагуудын үнэлгээ 86.0 хувьтай үнэлэгдсэн. Байгууллагуудын нягтлан бодогч нарын ажлын үнэлгээгээр 90.0-ээс дээш хувийн үнэлгээтэй 39, 80.0-90.0 хувийн үнэлгээтэй 32, 70.0-80.0 хувийн үнэлгээтэй 45, 60.0-70.0 үнэлгээтэй 16, 60-аас доош үнэлгээтэй 8 байгууллага байна.

Сумдын санхүүгийн албаны дарга нарыг чадавхжуулах сургалтыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулж, 2018 оны ажлыг 27 үзүүлэлтээр дүгнэхэд 60.-69.0 хувийн биелэлттэй 3, 70.-79.0 хувийн биелэлттэй 6, 80.0-90.0 хувийн биелэлттэй 8 сум дүгнэгдлээ.

Сум, байгууллагын 2018 оны төсвийн хэрэгжилтийг хангахад амжилт гаргаж, аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажилласан Буянт, Дөргөн сумын Засаг дарга нарыг нэг сарын албан тушаалын цалингийн 30 хувиар, зөрчилгүй дүгнэлттэй ажилласан байгууллагуудын 28 ахлах нягтлан бодогч нарыг албан тушаалын нэг сарын цалингийн 20.0-30.0 хувиар урамшуулахаар аймгийн Засаг даргын А/388, 389 дүгээр захирамж гарган шийдвэрлэлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр хуралдсан 9 дүгээр хуралдаанаас аймаг орон нутагт бий болсон орлогын боломж, өмнөх оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл, хэмнэлтийн үр дүнг тооцож орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг дэмжих, төсвийн өр авлагыг барагдуулах, үр ашгийг сайжруулахаар орон нутгийн 2019 оны батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хэлэлцүүлэн батлууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдаанаас аймгийн 2019 оны батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоолыг Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлж, санхүүжилтийн эрх нээлгэхээр аймгийн Засаг даргын 1/1605 дугаар албан бичгээр хүргүүллээ.

“Ховд дулааны станц” ТӨХК-ний хүсэлтийг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос компаний эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэмэгдүүлсэн “Тариф

батлах тухай” 243 дугаар тогтоол, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “Шим-ус” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах тухай” 32 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, суурь хураамжийн үнэлгээг 2 орчим дахин нэмэгдүүлэн шийдвэрлэсэн бөгөөд тус тогтоол нь энэ оны 6 дугаар сараас хэрэгжих болсонтой холбоотой төсөвт байгууллагуудын 2019 онд батлагдсан тогтмол зардал хүрэлцэхгүй болж орон нутгийн төсөвт ихээхэн хэмжээний өр үүсэхээр байгааг хэрхэн зохицуулалт хийж мөрдөх талаар шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд аймгийн Засаг даргын 1/1447 тоот албан бичиг хүргүүллээ.

Аймгийн нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэг шалгалтыг “Түүвэр шалгалт явуулах ажлын удирдамж”, нягтлан бодох бүртгэлийн газраас ирүүлсэн түүвэр шалгалт хийх квотыг үндэслэн аймгийн хэмжээнд 91 аж ахуйн нэгж, байгууллага болон төсөвт байгууллагыг сонгон үзлэг шалгалт явуулж дүнг нэгтгэн гаргалаа. Анхан шатны баримт хөтлөлт аймгийн хэмжээнд 77,6 хувьтай хэрэгжиж байгаагаас ААНБ-ууд 73,2 хувь, төсвийн байгууллагуудад 82,9 хувьтай шалгагдсан. НББ, санхүүгийн болон татварын тайлан хөтлөлт аймгийн хэмжээнд 83,6 хувьтай байгаагаас ААНБ-ууд хувьд 79 хувь, төсвийн байгууллагуудад 91,1 хувьтай хэрэгжиж байна. Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийн нэгдсэн дүнг гаргаж, хэлтсийн даргын 5/1189 тоот албан бичгээр Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газарт хүргүүллээ.

Тайлан, бүртгэлийг цахим программд боловсруулах ажиллагааг бүрэн нэвтрүүлэн төгөлдөршүүлж санхүүгийн салбарын мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэн сургах, хөгжүүлэх зорилгоор “Санхүүчдийг чадавхижуулах хөтөлбөр”-ийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн 2019 оны 66 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн А/390 дугаар захирамжаар аймгийн бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтаны 6 дугаар зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, 7 дугаар сарын 5-ны өдөр зөвлөгөөн зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Си Ти Эс ХХК-ний программ эзэмшигч 54 байгууллагын нягтлан бодогч, нярав нарт сургалт зохион байгуулж, програмгүй зарим төсөвт байгууллагуудыг шинээр холбууллаа.

Мянгад сумын Засаг даргын хүсэлтийн дагуу Санхүү, төрийн сангийн өрөнхий нягтлан бодогч, төсвийн мэргэжилтэн, төрийн сангийн дотоод хяналтын мэргэжилтэн нар тус суманд очиж санхүү, төсөв, түүний хэрэгжилтийн үйл ажиллагаанд нь хяналт, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүллээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хөшөөт хөгжил сангийн 2017-2018 он, Хөгжимт драмын театрын 2018 он, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017-2018 он, 14 дүгээр цэцэрлэгийн 2018 он, Ховд суварга ОНӨҮГ-ын 2017-2018 он, ахмадын хорооны 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна.

Аймгийн Статистикийн хэлтсээс нийгэм эдийн засгийн 5 дугаар сарын

танилцуулга бэлтгэж ЗДТГ-ын хэлтэс, агентлагын дарга нарт хүргүүлж, хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлж хэлтсийн веб сайтад байршуулав.

**Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:** Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймагт хэрэгжүүлэх “Иргэний эрх зүйн боловсрол” дэд хөтөлбөр, 2019-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдаанаар батлуулж хэрэгжүүлж эхлээд байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас аймгийн төвийн байгууллагуудын дарга нарт үндэсний аюулгүй байдлыг хангах талаарх үзэл баримтлал, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч сургалтанд 150 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа.

Жаргалант сумын Цаст-Алтай сургууль, 9 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчдаас аймгийн Засаг даргад ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулан 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр тус байгууллагуудад хяналт шалгалт хийж ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн Засаг даргад танилцуулж мэдээлэв.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн Музей, Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан, албан хаагчдад Төрийн албаны хууль болон дагалдаж гарсан журмууд, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн журмаар сургалтуудыг зохион байгууллаа.

Хууль зүйн салбарын хүрээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг дарга Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний 2019 оны хагас жилийн биелэлтийн тайлангуудыг гаргаж холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж ажиллав. Архивын тасгаас төрийн байгуулалтын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг угтаж 06 дугаар сарын 14, 18-ны өдрүүдэд сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, сүлжээний мэргэжилтэн нийт 45 албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Архивын лавлагаа магадлагааг нийт 55 хүнд олгосноос 15 хүнд архивын хуулбар хувь, 20 хүнд цалингийн тодорхойлолт олгосон ба 2 хөмрөгийн 3 дансны 1988-1993 оны 36 ширхэг хадгаламжийн нэгж буюу 3923 хуудсыг цахимд оруулав.

**Цагдаагийн газар:** Тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Улсын хэмжээнд явагдаж буй замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”, “Яараад яахав дээ” нэгдсэн арга хэмжээ, архи дан согтуурахтай тэмцэх чиглэлээр аймгийн хэмжээнд “No alcohol” хөдөлгөөний удирдамж, төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын болон аймгийн хэмжээнд авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, тоон үзүүлэлт, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцлийг арилгах,

урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 12 төрийн байгууллагын алба хаагч, сумдын иргэдийг хамруулан сургалт, мэдээлэл, яриа таниулгыг 1500 гаруй хүнд 19 удаа хийж гүйцэтгэсэн.

“No alcohol” хөдөлгөөний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын Ховд орон нутгийн хөтөлбөртэй хамтран Жаргалант сумын 12 багийн Засаг дарга, нийгмийн ажилтнуудад Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийг архи согтууруулах ундааны зүйл хэрэглэхээс татгалзах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр сургалт, мэдээлэл хийв. Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын Ховд орон нутгийн хөтөлбөртэй хамтран Жаргалант сумын архины хамааралтай гэр бүлийн гишүүн, өрх, иргэдийн судалгааг гаргаж 50 хүнд “Архинд үгүй гэж хэлье” нэг өдрийн сургалтыг, 17 сумын архины архаг хамааралтай 30 хүнд “Архинаас татгалзъя” 2 өдрийн сургалтыг вакумжуулсан хэлбэрээр тус тус зохион байгуулж, оролцогчдод “Талархал” хадгалуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагуудын цахим хаягт мэдээлэл байршуулан, иргэд олон нийтэд сурталчилсан.

Оюутан, сурагчдын зуны амралтыг үр бүлтээлтэй, зөв өнгөрүүлэх зорилгоор тэдний дунд “Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлье” сэдвээр богино хэмжээний видео сурталчилгаа зохион бүтээх уралдааныг зарлан, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилан ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Прокурорын газартай хамтран Буянт суманд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Малчдын бүлэг ажиллуулах үлгэрчилсэн дүрэм, бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, малын хулгайн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллага, иргэд, сайн дурын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор зүүн бүсийн сумдын малчдын бүлгийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, малчдын бүлгийн нийт 132 гишүүнийг үнэмлэхжүүллээ.

Буянт, Ховд, Мянгад, Дөргөн, Дуут, Эрдэнэбүрэн сумдад үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, малчдын төлөөллийг оролцуулсан “Дэвжээ” тэмцээн зохион байгуулж, амжилттай оролцсон багуудыг мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнаж, урамшууллаа. Арга хэмжээний үеэр зүүн бүсийн сумдын ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо” сэдвийн хүрээнд зарласан эссэ бичлэгийн уралдааныг дүгнэсэн.

Аймгийн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн дэргэд ажиллах “Шуурхай баг”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах талаар Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газарт хүсэлт хүргүүлж, багийн гишүүдэд 10.000.000 төгрөгийн шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шийдвэрлүүллээ.



Орон нутгийн “Олон ястан” телевизтэй хамтран ажиллаж, аймгийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, уралдаан тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, бусад ажил, арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд тухай бүр мэдээ, сурвалжлага хүргэж ажилласан.

Аймгийн хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 25-наас 06 дугаар сарын 25-ны байдлаар нийт 245 гомдол мэдээлэл хүлээн авсны 66 буюу 27 хувийг гэмт хэргийн шинжтэй, 179 буюу 73,0 хувийг зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 4, хүчиндэх 1, хулгайлах гэмт хэрэг 7, мал хулгайлах гэмт хэрэг 2, дээрэмдэх 3, залилах гэмт хэрэг 7, алдаатай гүйлгээ андуурсан илгээмж завших 1, эд хөрөнгө устгах, гэмтээх 1, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах 1, хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах 1, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 1, хууль бусаар мод бэлтгэх 1, авто тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 6, замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих 1 тус тус бүртгэгдсэн.

Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Бусдын биед халдах 5, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 5, авлига 1, залилах 6, дээрэмдэх 1, зам тээврийн осол 18, ЗХАБЖЗ 6, мал хулгайлах 2, ОНАТБА 16, завших 2, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 9, хулгайлах 14, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 5, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 19, хууль бусаар мод бэлтгэх 1, хууль сахиулагчийг эсэргүүцэх 5, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1, хүчиндэх 1, цахим доромжлох, гүтгэх 1, бусад 127 гомдол мэдээлэл тус тус хүлээн авсан.

Цагдаагийн газраас зөрчил гаргасан 134 хүнийг эрүүлжүүлж, 205 хүнийг 37,345,000 мянган төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 56 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 33 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан болно.

**Шүүхийн шинжилгээний алба:** Монгол Улсын хууль, Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын тушаал, албан даалгавар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2019 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний албанд 21 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж 125 ирүүлснийг хүлээн авч, эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим [khovd\\_nifs@yahoo.gov](mailto:khovd_nifs@yahoo.gov) хаягаар авч ажиллаж байна.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 7 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 80, эд эсийн шинжилгээ 7, хавтаст хэрэг 2, химийн 18, биологийн 5, криминалистикийн 6 шинжилгээг тус тус хийж, дүгнэлт гаргаж ажиллав.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 20 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 20 ширхэг мөр, гутлын мөр 14,

тээврийн хэрэгслийн мөр 13, бичил мөр 3, бусад ул мөр, эд мөрийн 21 баримтыг илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 15, гарын 9 мөрийг авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох, бүтцийн, химийн, биологийн, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүд, ирсэн тогтоолуудыг тухай бүрт нь цахим санд оруулж ажиллав.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тус хэлтэс нь тайлант сард нийт 2682 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас иргэний бүртгэлийн чиглэлээр 889, Үүнээс: аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 75 ба шилжин ирсэн иргэд 44, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 31, гадаад паспорт олголт 190, иргэний үнэмлэх шинээр олгосон 284, сунгалт 208 дахин олгосон 132, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэл 295 Үүнээс: төрөлт 198, үрчлэлт 5, овог, эцгийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэл 12, эцэг тогтоолт 8, гэрлэлт 40, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1, нас барсны бүртгэл 25, нөхөн бүртгэл 5, регистэр олголт 1,

Иргэний бүртгэлийн лавлагаа олголт 580, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 742, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 169 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Иргэдээс нийт 7 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 3 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 4 иргэний өргөдлийн хугацаа шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

**Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:**

**Боловсролын чиглэлээр:** Улсын физикийн 33, баруун бүсийн математикийн олимпиадын хүрээнд багш сурагчдын онол, арга зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор вакуум сургалтыг МУИС-ийн физик, математикийн тэнхимийн эрхлэгч, ХоИС-ийн багш нар хамтран удирдаж, аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн физикийн 26, математикийн 25, 8 дугаар ангийн 28, 11 дүгээр ангийн 36 сурагч Математик, Физикийн хичээлийн суурь ойлголтууд, математик физикийн хичээлийн агуулгын залгамж холбоо, хамаарал, бодлого бодох арга зүй ба хэрэглээ агуулгын хүрээнд онол, арга зүйгээ дээшлүүллээ.

ОХУ-ын Тувагийн их сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Кызыл дахь Тувагийн их сургуулиас зохион байгуулсан олон улсын сурагчдын зуны орос хэлний сургалтад аймгийн Прогресс сургуулийн 13 сурагч 1 багш, Алтайн хязгаартай хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн Цаст-Алтай сургуулийн 25, Чандмань сумын ерөнхий боловсролын сургуулийн 2 сурагч Барнаул хотноо олон улсын сурагчдын зуны орос хэлний сургалтад оролцож байна.

2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн боловсролын баримт бичгийг мэдээллийн системээс шууд хэвлэн гаргах тухай сайдын тушаал гарсантай холбогдуулан сургуулийн нэршлийг иргэний бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх, тамга тэмдэг, албан бланкыг өөрчлөх, системд бэлтгэл хангах, анги удирдсан багш судлагдахууны дүн оруулах, хувийн хэрэг иргэний үнэмлэх, болон суралцагчийн монгол бичгээр нэрийг тулган алдаатай бол системийн багийнханд өгч засуулах,

хэвлэх төхөөрөмж, интернетийн бэлэн байдлыг хангахтай холбоотой сургууль, насан туршийн боловсрол төвийн захирлууд, мэдээлэл технологийн багш нарын сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ үнэмлэхийн үнэт цаасыг хуваарийн дагуу сургуулиудад хувиарлан олгов. Сургалтад нийт 54 удирдлага багш нар хамрагдлаа.

Улсын физикийн 33 дугаар олимпиад Ховд аймагт зохион байгуулах болсонтой холбоотой Улаанбаатар хотод ажиллаж, амьдарч буй аймгаас төрөн гарсан физикч эрдэмтдийн төлөөлөлтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр: Улсын физикийн 33 дугаар олимпиадыг нэрэмжит болгох тухай, Олимпиадын хүрээнд гаргах номын эх бэлтгэх, багш сурагчдыг бэлтгэх асуудлыг хэлэлцэн санал солилцов.

Үндэсний бичгийн соёлыг залуу хойч үеийнхэнд сургах, өвлүүлэн үлдээх, монгол бичгийн унших, бичих үндсэн чадварыг ангийн сурагч бүрд олгох, монгол бичгийн соёл боловсролыг түгээгч багш, тээгч анги, бүлэг шалгаруулах, сурталчлах зорилгоор монгол бичгийн сургалт судалгааны “Ертөнц төв”-өөс 5 дахь жилдээ зохион байгуулж буй “Үндэсний өв соёлоо түгээгч, тээгч-2019” улсын уралдаан амжилттай зохион байгуулагдлаа. Уралдаанд 18 аймаг, 4 дүүргийн Ерөнхий боловсролын 160 сургуулийн 480 багш 6-12 дугаар ангийн 611 бүлгийн 16370 сурагчдыг бэлтгэн, Монгол бичгээр хурдан унших, хичээнгүй бичих чадвараа сорин өрсөлдөж, манай аймгаас нийт 12 сургуулийн 39 бүлгийн 1027 сурагч улсын уралдаанд оролцлоо.

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан, “Номын гэгээ” дэд хөтөлбөрийн хүрээнд сурагчдын авьяасыг нээн хөгжүүлэх, бүтээлчээр унших, бичих, сэтгэн бодож, дүрслэх чадварыг хөгжүүлэх зорилгоор Жаргалант сумын ЕБС-ийн 7-12 дугаар ангийн сурагчдын дунд “Дараагийн хуудас” ТВ нэвтрүүлгийг дэлхийн хүүхэд багачуудын унших дуртай, алдарт зохиол болох Америкийн зохиолч Ф.Борнетын “Цэнхэр цэцэгсийн орон”, Бразилийн нэрт зохиолч Пауло Коэльогийн “Алхимич” зохиолоор 2 удаа хийв.

Авьяас хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж тухайн сум, орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс тодорхой хөрөнгийг зарцуулж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, хүүхэд нэг бүрийн авьяас, чадварыг нээн хөгжүүлж нийт 431 төрлийн сонгон дугуйланд 445 багш удирдан чиглүүлж 82316600 төгрөгийн санхүүжилт зарцууллаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс боловсролын 6 заалт хэрэгжиж биелэлт 50%-тай, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын 13 заалт хэрэгжиж 60,7%-тай, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын 26 заалт, соёлын 25 заалт хэрэгжиж биелэлт 60,5%-тай, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд боловсролын 18 заалт, соёлын 19 заалт хэрэгжиж 48,6% тай, Засгийн газрын тогтоолын боловсролын 11 заалт хэрэгжиж 42% биелэлттэй хэрэгжиж холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүллээ. Сурагчдын шүдний өвчлөлийн талаарх амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт 16648 сурагчийг хамрууллаа.

№	Хамрагдалтын хувь/ тоо	Эрүүл шүдтэй	Өвчлөлтэй, цоорсон	Эрүүлжсэн %
---	------------------------	--------------	--------------------	-------------



		хүүхдийн %	шүдтэй сурагчийн %	
2018	93%-17294	40%	51%	34%
2019	16648-96%	31%	56%	20%
Харьцуулалт	3% өссөн	9% - буурсан	5% буурсан	6%буурсан

АНУ-ын Элчин сайдын яамнаас дэлхийн 80-аад оронд хэрэгждэг Аксесс хөтөлбөр хэрэгжиж аймгийн 4 сургуулиас шалгарсан 30 сурагч амжилттай төгслөө.

Аймгийн хэмжээнд 5 дугаар ангийг 70 бүлгээр 1800, сурагч 3 шалгалт, 9 дүгээр ангийг 75 бүлэгт 1589 сурагч 4 шалгалт, 12 дугаар ангийг 53 бүлэгт 914 сурагч 4 шалгалт өгч боловсролын салбарын мэдээллийн системд шалгалтын дүн оноогоор оруулсныг хүүхэд нэг бүрээр баталгаажуулсан. Ерөнхий боловсролын 25 сургууль, Насан туршийн боловсрол төвөөр 9 дүгээр ангийг өдрөөр 1510, дүйцсэн хөтөлбөрөөр 79 суралцагч, 12 дугаар ангийг өдрөөр 803 суралцагч, дүйцсэн хөтөлбөрөөр 111 суралцагч суралцан төгсөж боловсролын баримт бичиг болох суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэхээ хүлээн авлаа. 2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтыг 43 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, шалгалтад орвол зохих 1909 шалгуулагчаас 1774 шалгуулагч шалгалтад орж ирцийн дундаж хувь 92.9 байна.

Ховд аймгаас Прогресс сургуулийн 12а ангийн сурагч Үлэмжбуянгийн Батхүрэл, Ховд их сургуулийн лицей ахлах сургуулийн 12а ангийн сурагч Балдоржийн Тогтуунсүвд нар биологийн хичээлээр, Цаст-Алтай цогцолбор сургуулийн Алтанхуягийн Цэвэлмаа Монгол хэлний хичээлээр тус тус 800 оноо авч тухайн бүлгийг улсын хэмжээнд тэргүүллээ.

**Соёл, Спортын чиглэлээр:** Азийн Ардын урлагийн наадамд /2019 оны 12-16-ны хооронд болж нийт 14 улс орон оролцов/ аймгаас нийт 30 уран бүтээлч оролцож, ХДТ-ын Жангар хамтлаг, ХоИС-ийн Алтайн цуурай хамтлаг, Дуут сумын Урианхайн өв хамтлаг, ахмад залуу ардын авьяастнууд авьяас билгээ сорин уралдав. Наадмын эхний шатны шалгаруулалтанд аймгаас 15 авьяастан шалгарч, эцсийн шатны шалгаруулалтанд ахмад ардын авьяастан Г.Хонгороо ховор мартагдсан өв соёлоо сэргээн тоглосноороо шилдэг 8-д багтаж Олон улсын Ардын урлагийн холбоо, БСШУСЯ-ны “БАТЛАМЖ” мөнгөн шагналаар шагнагдлаа.

БСШУСЯ-аас зохион байгуулсан “Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага” 3 дахь удаагийн сургалтад аймгийн ЗДТГ-ын соёлын мэргэжилтэн, Театр, Музей, Номын сангийн удирдах ажилтнууд оролцож мэдлэг ур чадвараа дээшлүүлж мэдээлэл сонслоо.

**Музей:** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Өв соёлын хүрээлэнг эхчүүд, хүүхдүүдэд үнэ төлбөргүй үзүүлсэн бөгөөд энэхүү арга хэмжээнд 30 гаруй эхчүүд, багш нар 100 гаруй цэцэрлэг, сургуулийн насны хүүхэд багачуудыг хамруулан олон ястны түүх, соёлтой танилцуулж, “Монгол гэр барих уламжлалт арга” сэдвийн хүрээнд боловсролын ажил зохион байгууллаа.

ОХУ-ын “Звезда” телевизийн хамт олон Дэлхийн II дугаар дайны он жилүүдэд Монголчуудаас Зөвлөлтийн улаан армид бэлэг хандив, тусламж дэмжлэг үзүүлж байсан түүхийг өгүүлсэн баримтат киноны зураг авалт хийсэн бөгөөд энэхүү зураг авалтын багийнхантай хамтран ажиллав. 2019 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар баруун Монголын олон угсаатны өв соёлтой танилцахаар том хүн 73, хүүхэд 26, гадаад үзэгч 25, үнэгүй үзэгч 20 буюу нийт 144 үзэгч Музейг үзэж сонирхсон байна.

**Нийтийн номын сан:** Тайлант сард 88 уншигчдад шинээр карт нээж 4438 ирцэд 6093 ном, сонин хэвлэл олгож үйлчиллээ. Соёл хүмүүжлийн олон талт ажил 8, уралдаан тэмцээн 6, сургалт мэдээлэл 2, англи хэлний ярианы хичээл 4 удаа тус тус зохион байгуулж нийт 800 гаруй уншигч үйлчлүүлэгчид хамрагдав.

**Хөгжимт драмын театр:** Хүүхдэд зориулсан уран бүтээлийн төлөвлөгөөний дагуу Ц.Содномдоржийн зохиол “Норовын намтар” жүжгийг шинээр найруулж, хүүхдийн баяраар 1500 гаруй хүүхэд багачуудад толилуулав. Монгол улсын баатар Цэндийн Олзвойн 105 насны ойд зориулж хүүхэд залууст эх оронч үзэл төлөвшүүлэх үнэн түүхийг танин мэдүүлэх зорилгоор Д.Жүгдэрбарамын цомнол “Эх орны хүү” түүхэн бүжгэн жүжгийг сэргээн тавьж 2019 оны 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд нийт 3 удаагийн тоглолтоор 800 гаруй үзэгчдэд хүргэлээ.

ОХУ-ын Алтай мужид 06 дугаар сарын 08-15-нд болсон “Их Алтай-2019” аялал жуулчлал, спортын их наадам тэмцээнд Монгол улсаа төлөөлөн аймгийн БТСГ-ын 10 тамирчны бүрэлдэхүүнтэй баг оролцлоо. Уг тэмцээнээс Хаданд авиралт, куратор зэрэг төрлөөс 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Тайлант сард салбарын хагас жилд хийсэн ажлын тайланг нэгтгэж хүргүүлэх, Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Иргэдийн хурлын тогтоол шийдвэр, Засаг даргын Захирамжийн биелэлт, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тооцож холбогдох яам, хэлтсүүдэд хүргүүллээ.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр олон нийтийн дунд үер ус, салхи шуурга, хавсрага бороо, аянга дуу цахилгаан, хурц нар, зоонозын халдварт өвчнөөс сэргийлэхэд ард иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэхэд анхаарал тавин ажиллаж байна.

Орон нутгийн телевиз, сайтуудаар дамжуулан үер усны аюулаас сэргийлэх, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тарваган тахал өвчнөөс сэргийлэх зэрэг сурталчилгааны шторкийг иргэд олон нийтэд 7 хоног бүр 2 удаа мэдээлж байна. Цочмог халууралт цэврүүт тууралттай хам шинж 56, цочмог халууралт шарлалттай хам шинж 1, усархаг суулгалт 5, цочмог халууралт тууралттай хам шинж 6, нийт 68 өвчлөлийн тохиолдлын судалгааг EWAR 2.0 программ дээр бааз үүсгэн мэдээллийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалтын албанд хүргүүлж судалгаанд хамрууллаа

Аймгийн Зооноз өвчин судлалын төвд боомын хүний өвчлөлийн сэжигтэй Буянт сумын Норжинхайрхан багийн иргэний дуудлагыг хүлээн авч тархвар судлалыг тогтоон тусгаарлаж шинжилгээ авч оношийг тодруулахад үгүйсгэгдсэн байна. Тарваган тахлын 3600 хүн/тун вакцин Зооноз өвчин судлалын үндэсний

төвөөс ирүүлснийг тахлын голомттой 13 сумдад хуваарилан хүргүүлж энэ сарын сүүлийн 10 хоногт хийхээр төлөвлөөд байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр 6 сарын эхээр “Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх зөвлөгөө өгөх арга зүй” бүсийн сургалтыг 5 аймгийн өрхийн 50 эмч эмнэлгийн ажилчдыг, Жаргалант сумын сургуулиудын эмч, нийгмийн ажилтнууд 20, нийт 70 хүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулж эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулж мэдээллээр хангалаа.

Баруун бүсийн өрхийн эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, онолын мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор Баруун бүсийн "Өрхийн эмч таны төлөө бүхий л амьдралын тань туршид анхаарал тавьж халамжилна" сэдэвт уулзалт зөвлөгөөнийг Монголын өрхийн эмч нарын нийгэмлэг, аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар хамтран зохион байгуулсан нь өрхийн эрүүл мэндийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилсан, мэдлэг мэдээллээ хуваалцсан үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Эрүүл мэндийн яам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтран “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг үнэлэх судалгаа”-ны баг аймгийн Мянгад, Булган, Чандмань сумдын эрүүл мэндийн төв, Мөст сум дундын эмнэлэг, Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг тандан судалж судалгааны ажил боловсруулалтын шатандаа байна.

Швейцарийн хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны санхүүжилтээр Мөст, Үенч сумын эрүүл мэндийн төв, Баатархайрхан, Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулахад олон нийтийн оролцоо” төслийг хэрэгжүүлэх төслийн нээлтийг зохион байгуулж төслийн төлөвлөлтийг боловсруулан чадавхижуулах сургалтыг хамтрагч байгууллагуудыг оролцуулан зохион байгууллаа. Уг төсөл хэрэгжсэнээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд олон нийтийн оролцоог хангаснаар үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг бий болгож, иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн үр дүн гарна гэж үзэж байна.

Тайлант сард сумдад ажиллах батлагдсан хяналт шинжилгээ үнэлгээний хуваарийн дагуу Дарви, Зэрэг, Дөргөн, Чандмань, Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төв, Ариун шүд, Мөнхцохилохуй, Сувдан шигтгээ, Элбэрэлт бүжинлхам, Ивээл, Ховд мед, Ач заяа, Мөнгөн морьт хувийн эмнэлгүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж зөвлөмжийг хүргүүллээ.

Тус сард бүтэц, харьяаллын асуудлаас шалтгаалан үйл ажиллагаа нь зогссон “Өсвөр үеийн ирээдүйн босго төв”-ийг шинээр байгуулан эмч, мэргэжилтнийг сургаж бэлтгэн өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх, дадал хэвшлийг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж эхэллээ. Төв ажиллаж эхэлснээр 99 хүүхэд үйлчлүүлж, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээнд хамрагдсан 99 хүүхдээс онош тодруулах зорилгоор 21 хүүхдийг хяналтанд авч шинжилгээнд хамруулан 7 хүүхдэд эмийн эмчилгээ хийж, ерөнхий

боловсролын 9-12 дугаар ангийн нийт 938 сурагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

Эрүүл мэндийн яамнаас төрөх насны эмэгтэйчүүдийг жирэмслэлтээс сэргийлэх аргын эм хэрэглээнд 41.5 сая төгрөгийг төсөвлөн ирүүлснийг 16 сум, 6 өрхийн эрүүл мэндийн байгууллагаас санал авч 6 нэр төрлийн эм, хэрэгсэл худалдан авах цахим тендер зарлуулж 7 дугаар сарын 20-ны дотор нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Магадлан итгэмжлэлд Булган сумын нэгдсэн эмнэлэг, Мөнххайрхан, Дарви сумын эрүүл мэндийн төвүүд, Жаргалан, Баатархайрхан, Бугат, Булган өрхийн эрүүл мэндийн төвүүд хамрагдаж журмын дагуу шалгуулж материалыг хүргүүлээ. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг хийж, 14 байгууллагын ирүүлсэн материалын дагуу хэлэлцэж, Үенч, Дөргөн сумдад шинээр эмийн сан нээх зөвшөөрлийг олгож, 7 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгаж, 1 байгууллагын тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулж, 1 байгууллагын эрхийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, 1 байгууллагын үйл ажиллагааны эрхийг цуцлах арга хэмжээг авч ажиллав.

Тайлант оны 5 сарын 31-ний байдлаар нийт эрүүл мэндийн үзлэгийг 157844 хүнд хийж үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 36584 буюу нийт үзлэгийн 23.1 хувийг эзэлж байна. Төрөлт 5 дугаар сүүлээр 924 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 33 тохиолдлоор буурчээ. Нялхсын эндэгдэл 18 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 19.4 промилль буюу өмнөх оны мөн үеэс 4.7 промиллээр, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 21 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 22.7 промилль буюу 4.9 промиллоор өссөн үзүүлэлттэй байна.

Халдварт өвчин 5 дугаар сарын байдлаар 348 тохиолдол буюу 10000 хүн амд 39.4 буюу өмнөх оны мөн энэ үеэс 11.4 продицемилээр өсч, нийт халдварт өвчний 36.4 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 4.5 хувийн сүрьеэ, 43.6 хувийг салхин цэцэг өвчин тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2 дахь заалтаар тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж авах 3 хүний 25,0 сая төгрөг, “Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж”-ийг 27 хүнд олгохоор холбогдох бичиг баримтыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж тэтгэмжээ авах боломжийг бүрдүүлээ.

Тайлант сард төсвийн тодотголд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дээврийн засварт 195 сая, Амаржих газартай хоолойгоор холбоход 268 сая төгрөг, Бугат өрхийн гадна халаалтын шугам сүлжээний зардалд 58.2 сая, Булган сумын Нэгдсэн эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 12.0 сая төгрөгийг тус тус шийдвэрлүүлээ.

**Тав: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар:** Тайлант хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 25, Тэргүүлэгчдийн 88 тогтоол, 1 хуралдааны тэмдэглэл хүлээн авч хяналтын карт хөтөлж, танилцуулах хуудсаар аймгийн удирдлагуудад танилцуулж, хэлтэс, сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ өгч тооцон гаргахад 2019 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн ИТХ-ын 135 тогтоол шийдвэрийн 264 заалт 76.0 хувийн хэрэгжилттэй тооцогдлоо. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын талаар нэг бүрчлэн авч үзвэл:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 123 тогтоолын 228 заалт дунджаар 81.3 хувьтай;

2. Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааны 2 тогтоолын 8 заалт дунджаар 68.7 хувьтай;

3. Аймгийн ИТХ-ын 8 тогтоолын 24 заалт дунджаар 66.7 хувьтай;

4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны 2 тэмдэглэлийн 4 заалт 77.5 хувьтай тус тус хэрэгжсэн байна. Түүнчлэн аймгийн ИТХ-ын бүрэн хэрэгжсэн, хэрэгжүүлэх хугацаа дууссан, хүчингүй болгосон зэрэг 31 тогтоол шийдвэрийн 55 заалт болон хэрэгжилтийн явц удаашралтай байгаа 4 тогтоолын 5 заалтыг жагсаалтаар гаргаж, тогтоол шийдвэрийн биелэлтийн хамт 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/1490 тоот албан бичгээр аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлэв.

“Ховд аймгийн хөгжлийн стратеги” /2015-2025 он/-ийн зорилтуудын хэрэгжилтийг ханган ажиллаж, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу төсөл, арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн явцад бодлогын баримт бичгийг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ өгч дүгнэхэд хөгжлийн стратегид тусгагдсан 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 201 төсөл, арга хэмжээ 44.67 хувийн хэрэгжилттэй байна. Хөгжлийн стратегийн хэрэгжилтийн явцыг авч үзвэл:

1. Тогтвортой өсөн нэмэгдэх хүн амтай болох 1 дүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 50.0 хувьтай

2. Оюунлаг, бүтээлч иргэдийг хөгжүүлэх 2 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 32 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 46.9 хувьтай

3. Олон үндэстэн, ястны соёл иргэншлийн уламжлал, шинэчлэл, эв найртай амьдралыг цогцлоох 3 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 19 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 36.3 хувьтай

4. Хүн байгалийн шүтэлцээг хангах 4 дүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 25 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 38.8 хувьтай

5. Ухаалаг, нээлттэй засаглалтай байх 5 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 16 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 63.75 хувьтай

6. Амьдрах таатай орчныг бүрдүүлэх 6 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 16 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 40.0 хувьтай

7. Уламжлалт аж ахуй, аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангах 7 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 50 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 43.2 хувьтай

8. Хөгжлийн дэд бүтцийг байгуулах 8 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 30 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 45.0 хувьтай тус тус



хэрэгжсэн бөгөөд стратегийн биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/1491 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүллээ.

Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын тушаалын аймаг орон нутагт хэрэгжүүлэх 162 шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлэх 263 зүйл заалтын биелэлт 2019 оны эхний хагас жилийн байдлаар дунджаар 70.2 хувийн биелэлттэй байна.

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрүүдийн 263 зүйл заалтын хэрэгжилтийн үнэлгээг шийдвэр тус бүрээр товч танилцуулбал: -Монгол Улсын хуулиас хэрэгжүүлэх 1 хуулийн 2 зүйл заалтаас “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй 2 зүйл заалт, дунджаар 30 хувийн биелэлттэй байна.

- Улсын Их Хурлын тогтоолоос хэрэгжүүлэх 2 тогтоолын 3 зүйл заалтаас “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 3 зүйл заалт, дунджаар 70 хувийн биелэлттэй байна.

- Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолоос хэрэгжүүлэх 2 тогтоолын 3 зүйл заалтаас “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 1 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 2 зүйл заалт, дунджаар 80 хувийн биелэлттэй байна.

- Ерөнхийлөгчийн зарлигаас хэрэгжүүлэх 4 зарлигийн 5 зүйл заалтаас “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 2 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 2 зүйл заалт, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй 1 зүйл заалт, дунджаар 74 хувийн биелэлттэй байна.

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжөөс хэрэгжүүлэх 2 зөвлөмжийн 2 зүйл заалтаас “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 2 зүйл заалт 70 хувийн биелэлттэй байна.

- Засгийн газрын тогтоолоос хэрэгжүүлэх 113 тогтоолын 165 зүйл заалтаас “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 42 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 82 зүйл заалт, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй 34 зүйл заалт, “хэрэгжээгүй” буюу тасарсан 1 зүйл заалт, “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” эсвэл үнэлэх боломжгүй 5 зүйл заалт, дунджаар 66.4 хувийн биелэлттэй байна.

- Ерөнхий сайдын захирамжаас хэрэгжүүлэх 3 захирамжийн 7 зүйл заалт, “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 3 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 4 зүйл заалт, дунджаар 82.8 хувийн биелэлттэй байна.

- Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээс 31 тэмдэглэлийн 47 зүйл заалтаас “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 13 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 26 зүйл заалт, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй 7 зүйл заалт, “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” эсвэл үнэлэх боломжгүй 1 зүйл заалт, дунджаар 70.8 хувийн биелэлттэй байна.

- Албан даалгавраас хэрэгжүүлэх 2 албан даалгаврын 14 зүйл заалтаас “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 5 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 5 зүйл заалт, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй 4 зүйл заалт байгаа ба дунджаар 69.3 хувийн биелэлттэй байна.

- ЗГХЭГ-ын даргын тушаалын 2 шийдвэрийн 15 зүйл заалтаас “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувийн биелэлттэй 7 зүйл заалт, “хэрэгжих шатанд” буюу 70 хувийн биелэлттэй 6 зүйл заалт, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн биелэлттэй 2 зүйл заалт байгаа ба дунджаар 78.8 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймаг орон нутагт холбогдолтой 71 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 105 арга хэмжээний биелэлтийг тооцож, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болгоод байна.

Хөтөлбөрт тусгагдсан 71 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг салбар тус бүрээр нь товч танилцуулбал:

- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 20 зорилтын 30 арга хэмжээний биелэлтийг тооцоход “үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 16 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 10, “үр дүнгүй” буюу 0 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ, “үнэлэх боломжгүй” буюу орон нутгаас үл хамааран хэрэгжээгүй арга хэмжээ 1 байгаа ба үнэлгээний дундаж 59.3 хувьтай үнэлэгдсэн байна.

- Нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 17 зорилтын 24 арга хэмжээний биелэлтийг тооцоход “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 13 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 6 арга хэмжээ, “үр дүнгүй” буюу 0 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ, “үнэлэх боломжгүй” буюу орон нутгаас үл хамааран хэрэгжээгүй арга хэмжээ 3 байгаа ба үнэлгээний дундаж 54.8 хувьтай үнэлэгдсэн байна.

- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 16 зорилтын 34 арга хэмжээний биелэлтийг тооцоход “үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 17 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 14, “үр дүнгүй” буюу 0 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ байгаа ба үнэлгээний дундаж 57.6 хувьтай үнэлэгдсэн байна.

- Засаглалын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 5 зорилтын 7 арга хэмжээний биелэлтийг тооцоход “үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 4 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 1 арга хэмжээ байгаа ба үнэлгээний дундаж 74.3 хувьтай үнэлэгдсэн байна.

- Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулах заалтуудын хүрээнд хэрэгжүүлэх 10 арга хэмжээний биелэлтийг тооцоход “үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 3 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 5 арга хэмжээ байгаа ба үнэлгээний дундаж 61 хувьтай үнэлэгдсэн байна.

Нийт арга хэмжээний биелэлтийг тооцож хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд “үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй 8 арга хэмжээ, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувийн үнэлгээтэй 53 арга хэмжээ, “эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн үнэлгээтэй 36 арга хэмжээ, “үр дүнгүй” буюу 0 хувийн үнэлгээтэй 3 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байгаа ба үнэлгээний дундаж 59.5

хувьтай үнэлэгдсэн байна. “Үнэлэх боломжгүй” 4 арга хэмжээ байгаа нь орон нутгаас үл хамаарсан, гадаад хүчин зүйлээс хамааралтай төсөв хөрөнгө олгогдоогүйгээс тасарч буй арга хэмжээ юм.

Увс аймагт 2019 оны 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний уялдааг хангах нь” сэдэвт баруун бүсийн сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон ТЗУХ, ХШҮДАХ, ХОХБТХ-ийн төлөөлөл оролцов. Сургалтыг Увс аймгийн ЗДТГ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, “Дэлхийн банкны Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран зохион байгуулж, сургалтанд баруун 5 аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хөрөнгө оруулат, хөгжлийн бодлогын хэлтэс, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Увс аймгаас сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, агентлагуудын мэдээ тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, нийт 120 хүн хамрагдаж, сургалтанд оролцогчид хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын чиг хандлага, бусад аймгийн арга туршлагаас харилцан суралцах, эерэг харилцаа хандлага өөрийн сайн туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх, бусдаас суралцах, бусдыг харилцан хүндэтгэх, нэгж ажилтны чадавхыг бэхжүүлэх нь зэрэг сэдвийн хүрээнд өөрсдийн сайн туршлагаа харилцан солилцлоо.

Тайлант сард Засгийн газрын тогтоол 56, хуралдааны тэмдэглэл 11, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 1 тушаалийг хүлээн авч хяналтын карт хөтлөн, аймгийн удирдлагуудад танилцуулан, удирдлагын заалтын дагуу сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

#### **Зургаа: Сумдын мэдээлэл:**

**Манхан сум:** “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг Сумын Засаг даргын захирамжаар зохион байгуулах комисс томилон, тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Тус үйл ажиллагааны хүрээнд “Алдарт эх”-ийн одон “Дархан бэр”, “Хатан бэр” өргөмжлөл гардуулах үйл ажиллагааг сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл, Соёлын төвтэй хамтран зохион байгууллаа.

“Хөх мөнх Мянгад сан”-тай хамтран “Нутаг минь” урлагийн наадмыг 2019 оны 06 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд сумын төвд зохион байгуулж, уг үйл ажиллагааны үеэр Захчин гэр, Захчины түүх, соёлын хэрэгслээр үзэсгэлэн гаргалаа.

Аймгийн Залуучуудын холбоотой хамтран сумын Залуучуудын нэгдсэн чуулга уулзалтыг 2019 оны 06 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулж, спорт урлагийн 7 төрлөөр хурд хүчээ сорин өрсөлдөж Баянгол багийн залуучууд тэргүүн байрыг эзэллээ. Энэхүү ажлын хүрээнд сумын цолгүй залуу бөхчүүдэд цол олгох барилдааныг зохион байгуулж залуу бөх Г.Галмандах түрүүлж сумын начин цол хүртлээ.

Иргэдийг эрүүл аюулгүй ундны усаар хангах зорилгоор Дэлхийн зөн Олон улсын байгууллагын санхүүжилтээр Баянтүмбэ тавьтад 54 сая төгрөгийн өртөгтэй гүний худгийг ашиглалтанд оруулж, хүлээн авлаа.

Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын хүрээнд цагдаагийн хэсгээс сурагчдын амралт, иргэдийн аялал зугаалгын улирал эхэлсэнтэй холбогдуулан иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар санамж, сэрэмжлүүлгийг хүргэж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн Газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлт, аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлт, аймгийн Засаг даргын захирамж албан даалгаврын биелэлтийг нэгтгэж Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст хүргүүллээ.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан 43 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр туувар замд саатуулж, хорио цээрийн хяналтанд авах журмын дагуу Манхан сумын Засаг даргын 2019 оны А/58 тоот захирамжаар дамжин өнгөрүүлэх, байршил тогтоох тухай захирамж гаргаж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Малын угаалга, туулгалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, ажлын явц сумын дүнгээр 60 хувьтай байна.

Аймгийн мал эмнэлгийн газраас өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу Мал эмнэлгийн тасгийн дарга, тархвар зүйч, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар удирдамжийн хүрээнд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ үйлчилгээнд гүйцэтгэлийн хяналт хийж, Тахилт, Улаанхүрээ, Ботгон багуудын малчидтай уулзаж мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг хийж өрх бүрийн малын эрүүл мэндийн дэвтэртэй танилцаж, малын эрүүл мэндийн түвшинг тогтоож ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн анги дэвших болон улсын шалгалтыг амжилттай зохион байгуулж, суурь боловсролыг 50 сурагч, бүрэн дунд боловсролыг 36 суралцагч суралцаж төгслөө.

Сумын Хүүхдийн цэцэрлэгт хамран сургах тойргийн 2-5 насны 433 хүүхдээс үндсэн бүлэгт 174, нүүдлийн сургалтанд 124, явуулын сургалтаар 19, өөр аймаг, сумын цэцэрлэгт 28 хүүхэд хамрагдсан. Зэрэг гол, Ботгон, Баянгол, Тахилт багт гэр цэцэрлэг ажиллуулж сургалтын төгсгөлд хүүхдийн сурсан мэдсэн зүйлийг эцэг эхчүүдэд тайлагналаа.

Сумын Эрүүл мэндийн төв тайлант сард 663 үйлчлүүлэгчдэд амбулаторын үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгээр 313 хүнд үзлэг хийлээ. Эмнэлэгт 49 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 7 удаагийн алсын дуудлаганд явж үйлчилсэн. Товлолын дархлаажуулалтанд 43 хүүхэд хамрагдаж, “Улаанбурхан өвчинд цэг тавъя” уриан дор зохион байгуулж байгаа вакцинжуулалтанд нийт 860 гаруй хүүхэд хамрууллаа. 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна.

Манхан сумын харъяат Монгол Улсын Волейболын спортын мастер, ахмад тамирчин Умдэлэгийн Баттулгын нэрэмжит “Ховд-2019” ахмад Волейболчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 06 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд эрэгтэй 40-49, 50-с дээш нас,

эмэгтэй 36-45, 46-аас дээш насны ангиллаар нийт 19 багийн 140 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

**Дуут сум:** Сумын ИТХ-ын 2016-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг удирдлага болгон орон нутгийн хөгжил ард иргэдийн сайн сайхан амьдарлын төлөө өөрчлөлт, шинэчлэл, бүтээн байгуулалтын томоохон зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 9 удаа хуралдаж суманд тулгамдаад буй 21 асуудлыг хэлэлцэн 17 тогтоол гаргасан. Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах, Төрийн одон медальд тодорхойлох, Алдарт эхийн одон, Хурлын тов зарлах тухай төсөвт байгууллагуудын тайлан мэдээ хэлэлцэх тухай асуудлыг хэлэлцүүлэн шийдвэр гаргаж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2019 оны хагас жилд 32 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 90,3 хувьтай биелсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл 2019 онд нийт 15 ажил төлөвлөснөөс эхний хагас жилд 7 ажил гүйцэтгэлээ.

Сумын Татварын орлого эхний 6 сарын байдлаар 8135,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс 11235.1 мянган төгрөг оруулж биелэлт 38 хувь илүү давж биелэсэн. Төрийн сан 998 ширхэг гүйлгээний 521623.2 мянган төгрөгийн гүйлгээг хянан баталгаажуулж, төсвийн байгууллагын зарлага санхүүжилтийг цаг хугацаанд нь гүйцэтгэж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаанд үндэслэж шинээр ажлын байр бий болгох хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх жижиг зээлд тус сумаас ХААН банкнаас 2 иргэн, төрийн банкнаас 1 иргэн зээлэнд хамрагдаж 3 ажлын байр бий болгосон. Нийтийг хамарсан ажлаар сумын төвийн хогийн цэгийн орчин тойронг цэвэрлэж 15 иргэн, зохион байгуулалтын ажилд 8 иргэн бүгд 23 иргэн ажиллаж 6600,0 төгрөг зарцуулсан

Нийгмийн халамжийн тэтгэвэр 26 иргэнд, тэжээгчээ алдасны тэтгэвэр 4 иргэнд, хэлгүй дүлий 4 иргэнд харилцаа холбооны зардал, 20 иргэнд асаргааны тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдэд тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 2 эхэд асаргааны тэтгэмж, эм тарианы хөнгөлөлт 16 иргэнд, 0-18 насны 3-аас дээш хүүхэдтэй өрх толгойлсон 2 иргэнд улирлын тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдэд сургуульд ирж очих унааны зардал, жирэмсэн амаржсаны тэтгэмж 36 эхэд, 0-3 насны хүүхдээ асарч байгаа 146 эхэд сарын 50000 төгрөгийн тэтгэмж, 4 ахмад шүдний протез, өвдөгний үе хийлгэсэн 1 ахмадад протезийн зардал тус тус олгож ажиллав.

Сумын Хүүхдийн цэцэрлэг нь Монгол улсын Засгийн газрын тогтоол, БСШУСЯ-с гарсан тушаал шийдвэр болон бусад хууль тогтоомж, дүрэм журмыг байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Хүүхдийг багаас нь зөв цэвэр хооллох, сургалтын үед гарсан цаас хогийг түүж хогийн саванд хийж хэвших дадлуудыг эзэмшүүлж байна. Бүлэг бүрт хаягдал материалыг ашиглан хогийн сав хийх, өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлан “Цэвэр орчин бидний ирээдүй” сэдэвт уралдаан зарлаж, эцэг эхчүүд сүүний хайрцаг, алимны сагс ашиглан 3 бүлэгт 6 ширхэг хогийн сав хийж багаар ажиллахад нийт 32 эцэг эх, 12 багш ажилтан, ахлах бүлгийн 18 хүүхэд хамтран ажиллалаа.



Хамран сургах тойргийн 2-5 насны хүүхдийг цэцэрлэгт хамруулах, хамран сургалтыг 0,5 хувиар нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Үндсэн бүлэгт 89 хүүхэд буюу 45.9%-ийг хамруулсан. Хөдөөгийн 3 багт гэр цэцэрлэгээр 82 хүүхэд буюу 42.2 хувийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Эцэг, эхчүүдэд бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чадвар олгох чиглэлийг хувилбарт сургалтын хэлбэрт оруулж, гэр цэцэрлэг ажиллах хугацаанд баг бүрт 2 удаа сургалт явуулахаар төлөвлөсөн. Үндсэн бүлгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд “Хүүхэд бүрийг эрсдлээс хамгаалах”, “Хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд эцэг эхийн оролцоо” сэдвээр 2 удаа сургалт явуулахад давхардсан тоогоор 49 эцэг эхчүүд хамрагдлаа.

“Ном” хөтөлбөрийн хүрээнд зургийн болон сэтгэх чадварыг хөгжүүлэх дугуйлангийн 48 хүүхдүүдийн хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж тэргүүний бүтээлүүдийг олон нийтэд сурталчиллаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль элсэлтийн ерөнхий шалгалтанд 24 шалгуулагч 53 хичээл сонгон шалгалт өгч 534,3 оноогоор аймагт 6 дугаар байр эзэлж аймгийн “Шилдэг үнэлгээтэй” сургуулиар шалгарсан. Төгсөгчдийн 47.8 хувь нь төрийн ТОП их сургуульд элсэн суралцаж, 75 хувь нь дараагийн шатны их дээд сургууль, коллежид элсэн суралцаж байна

Улсын шалгалтад нийт 33 шалгуулагч орсноос түвшингээр нь авч үзвэл: 5 дугаар ангийн шалгалтын дундаж 67%, 9 дүгээр ангийн дундаж 59.3% шалгагдлаа. Анги дэвших шалгалтын дундаж 3,4 дүгээр ангийн дундаж 68.3%, 6,7,8 дугаар анги 61.3%, 10,11 дүгээр ангийн дундаж 87 хувь тус тус шалгагдлаа. Шалгалтын явцад ямар нэгэн зөрчил гомдол гарсангүй

2017-2018 оны хичээлийн жилд аймгийн БСУГ-ын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол хэлний хичээлийн чанарыг сайжруулах сургуулийн төлөвлөгөө боловсруулан эцэг эх, монгол хэл уран зохиолын багш, бага ангийн багш, нийт сурагчдад монгол хэлний сургалтын өнөөгийн байдал, цаашид ажиллах чиглэлийн талаар мэдээлэл хийж, сургуулийн захиргаанаас баталсан цагийн хуваарийн дагуу давтлага нэмэлт хичээл орох хуваарь гарган сурлагын чанар ахиулахад анхаарч ажилласнаар сурагчдын дүрмийн мэдлэг, зохион найруулах чадвар, зөв бичих чадвар сайжирлаа.

“Үндэсний бичгээ дээдэлцгээ” монгол бичгийн аян нийт ард иргэд, сурагчдын дунд өрнүүлэн “Сайхан бичигтэн”, “Тэргүүний уншигч”-ийг шалгаруулж давхардсан тоогоор 105 сурагч, 50 гаруй иргэдийг хамруулан ажиллав. Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хүүхдийн авьяасыг нээх, хөгжүүлэх, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, баяжуулах, өөрийгөө танин мэдэх нээж илрүүлэх, хөгжих боломжийг хангахад багш, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөв хандлагатай иргэн төлөвшүүлэх зорилгоор 21 төрлийн сонгон секц дугуйланд давхардсан тоогоор 605 хүүхдийг хамруулав. Үүнээс бага ангийн 171, дунд ангийн 313, ахлах ангийн 197 сурагч хамрагдлаа.

“Номын гэгээ” хөтөлбөрийн хүрээнд нийт давхардсан тоогоор 206 сурагч, 42 багш ажилтан, 242 иргэн, 4 байгууллагатай хамтран ажиллаж 8 бүтээлч ажил зохион байгуулж 934 номыг хандив, төсөл хөтөлбөрийн хүрээнд нийлүүлж ажиллав. Багшийн хөгжлийг дэмжих хүрээнд нэг, хоёр, гурав, арав дах жилдээ

ажиллаж буй багшийн сургалтанд 4 багш, ажилтан хамрагдаж, мэргэжил боловсролоо дээшлүүлж, нэгж дээр мэдлэг боловсролоо дээшлүүлэх сургалтыг сард 1 удаа 21 багшид нийт 168 хүн цагийн сургалт зохион байгуулав.

Сумын Эрүүл мэндийн төвийн 559 өрхийн 2084 хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэж байна. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулж /нийт 3 зорилтод 14 зүйл төлөвлөж/ байгууллагын ажилчдын хурлаар хэлэлцэж, ЗДТГ-аар батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн дагуу төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтанд төрийн сангийн зардлаар хүүхдийн сувилагчийг 3 сарын, чадавхижуулах сургалтанд 14 эмч сувилагч хамрагдлаа. Дотоодын сургалтыг 7 хоног бүр хийж хэвшсэнээс чухал шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийн судалгаа гаргалаа.

Сумын Засаг даргын захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй чанарын алба байгуулж, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, өвчний түүх хөтлөлт, оношилгоо, эмчилгээний стандартад хяналт тавин ажиллаж байна.

**Жаргалант сум:** Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Жаргалант сумын Засаг даргын 2019 оны А/29 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/15 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган төрийн захиргааны нийт 17 албан тушаалын 28 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, төрийн албаны зөвлөлд хянуулж баталгаажуулахаар хүргүүллээ.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4 дүгээр хуралдаан 2019 оны 06 дугаар сарын 26-ний өдөр хуралдаж Жаргалант сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хагас жилийн хэрэгжилтийн гүйцэтгэлийн үр дүнг хэлэлцэн “хангалттай” хэрэгжсэн гэж дүгнэгдлээ.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал, Ховд хотын хөгжлийн төлөө сан байгуулах, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам, Төв талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт үйл ажиллагаа, ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үйлчилгээний хөлс авах, түүнийг зарцуулах журмыг хэлэлцэн баталлаа.

Жаргалант сумын хэмжээнд нийт 4 ээж алдарт эхийн 1 дүгээр одон, 96 ээж алдарт эхийн 2 дугаар одонгоор шагнагдлаа. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Нийгмийн хөгжилд Залуу ээжүүдийн оролцоо” сэдэвт арга хэмжээг 05 дугаар 31-ний өдөр зохион байгуулж 25-40 насны алдарт эхийн I, II одонтой 416 ээж оролцсон. Мөн баг тус бүрээс алдарт эхийн I, II одонтой ахмад ээжүүдийг аймгийн Засаг дарга хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Нийтийн номын сан хамтран гэртээ хүүхдээ асран хүмүүжүүлдэг ээжүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие биенээ хүндэтгэх, өөрийгөө бусдад таниулах, бусад ээжүүдээс суралцах, тэднийг ном унших үйлчилгээнд татан оролцуулах зорилгоор 12 багийн 60 гаруй ээжүүдийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд хамтран бүтээлч ажил хийх, номын сангийн үйл

ажиллагаатай танилцах, Kindle ашиглуулж асуулт хариултын тэмцээн, ээжүүдэд үнэгүй карт нээх, шинэ номын үзэсгэлэн, номын фондтой танилцуулах, “Угийн бичиг”-ийг хөтлөх арга зүйн мэдээлэл өгч ажиллав.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/236 дугаар тушаалаар батлагдсан хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй рахит, тураал, цус багадалт зэрэг суурь өвчлөлтэй 0-3 насны хүүхдийг зуны сувилалд 06 дугаар сарын 24-ний өдрөөс хамруулж эхлээд байна.

Сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гаднах тохижилт, тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж сумын орон нутгийн хөгжлийн сангаас тус бүр 2 сая төгрөг буюу нийт 10 сая төгрөгийн санхүүжилт үзүүллээ.

Сумын Засаг даргын 2019 оны А/114 тоот захирамжийн дагуу оны хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, 12 багийн 186 малчин өрх 520 мал бүхий өрх 5 албан газрын 124215 толгой мал тоологдсоноос тэмээ 401 толгой, адуу 6991 толгой, үхэр 12132 толгой, хонь 38107 толгой, ямаа 66584 толгой тоологдсон. МИД судалгаанд хамрагдсан 91 өрх, нэг аж ахуйн нэгжийн судалгааг авч нэгтгэн малын программд шивж, дүнг статистикийн хэлтэст хүргүүллээ.

Сумын хэмжээнд 5 албан газар, 2 аж ахуйн нэгж 141 иргэн нийт үр тариа 8 га-д, тэжээлийн ургамал 15 га-д, төмс 61,7 га-д, хүнсний ногоо 116 га талбайд тус тус тариалалт хийсэн. Харзны эх мал эмнэлэгийн үржлийн нэгжтэй хамтран Цагаан гол, Таван хар, Зумъяагийн чиглэлд байгаа 15 малчин өрхийн 7155 толгой малыг угаалгад хамруулаад байна.

Сумын Засаг даргын 2019 оны А/115 дугаар захирамжийн хүрээнд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 158 дугаар тогтоол “Буянт голын сав дагуу газарт дагаж мөрдөх журам”-ын хэрэгжилтийг ханган лагерт гарсан 400 гаруй өрхөөс 700 гаруй мянган төгрөгийн хураамжыг төвлөрүүлэн хурсан хогийг ачиж зайлуулах, бие засах газрын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулж, нийт 17ш бие засах 00-ыг лагерт байршууллаа.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, зорилтот бүлгийн 30 иргэнийг цалинжуулан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал цэвэрлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зүлэг, цэцэгний үр суулгах ажил хийлгэж түр ажлын байраар ханган ажиллаж байна.

**Эрдэнэбүрэн сум:** 1. “Инээж буй эрүүл хүүхэд” уриан дор сумын хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлж нийт 250 гаруй хүүхэд оролцож, хүүхэд багачуудын дунд АХА, гүйлт, олс таталт, чөлөөт бүжгийн тэмцээн, шатар, даамын тэмцээн зохион байгуулагдаж аж ахуйн нэгжүүд, байгууллагууд нийт 411000 мянган төгрөгөөр ивээн тэтгэж оролцов. Мөн “Алдарт эхийн одон”-оор шагнагдаж буй эхчүүдэд шагнал гардуулав.

2. Манхан, Баян-өлгий аймгийн Толбо сумдын ИТХ, ЗДТГ-ын төрийн албан хаагчдийн туршлага солилцох уулзалт зохион байгууллаа.

3. Хагас жилийн мал тооллого 2019 оны 06 дугаар сарын 03-10-ны хооронд зохион байгуулагдаж дууслаа. 93 өрх түүвэрлэгдсэн Баянгол баг 21 өрх, Намарзан баг 12 өрх, Шураг баг 29 өрх, Хонгио баг 19 өрх, Хар-ус баг 12 нийт малын тоо 189966 болж нэмэгдсэн дүн гарлаа.

4.Сумын ногоон байгууламжийн усалгаа шуудуу болон дулааны шугамын хоолойн дээгүүр явдаг шуудууг зохион байгуулалттай ажил эрхлэх бүлгийн ажилчдаар нийт 30м шуудууг доторлож цементлэсэн.

5. Байгаль орчны “Тогтвортой хөгжлийн” төслийн дунд хугацааны /2019-2021/ оны төлөвлөгөө гарган сумын ИТХТ-ийн 23 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

6. Зэрлэг ан амьтдын байршил газар нутгаар явж хяналт, мониторинг хийх ажлын удирдамж гарган сумын Засаг даргаар батлуулан Хонгио багийн Дунд нуруу, Урт дав, Хожгор, Зурхайч, Хаварзан, Булаг Дунд хар, Ямаат улаан зэрэг газруудад хяналт хийлээ.

7. Азийн хөгжлийн банкны төслийн баг Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэл, усалгаатай газар тариалан сэдвээр ногоочдод сургалт зохион байгуулав. Сургалтанд 25 ногоочид оролцов.

8. АТБӨЯТХ-ийн үзлэгт нийт 268 авто машин хамрагдаж агаарын бохирдлын төлбөрт 675.5 мянган төгрөг, автын татварт 9583.8 мянган төгрөгийг тус тус улс, аймгийн төвлөрсөн төсөвт тушаав. Ашиглах боломжгүй болсон 3 тээврийн хэрэгсэл улсын бүртгэлээс хасагдах бичиг баримтыг бүрдүүлэн авч үзлэгийг амжилттай амжилттай зохион байгууллаа.

9.Сумын ИТХ-ын ээлжилт хуралаанаар газар тариалангийн бүс тогтоож, журам батлах, төсвийн байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлээр тавих хяналт, цаашдын зорилтын талаар хэлэлцлэв.

**Дөргөн сум:** Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг албан байгууллагуудтай хамтран 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан. Энэхүү өдрөөр бүх насны хүүхдийн онцлогт тохирсон дугуйн уралдаан, буухиа, бөхийн барилдаан, гүйлт, гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнийг тус тус зохион байгуулж 1-3 дугаар байр эзлүүлэн шагнаж урамшууллаа. Алдарт эхийн 2 дугаар одонг 14 эхэд гардуулж өгсөн.

Монгол орны баруун бүс нутаг, мал зэрлэг амьтдын хооронд халдвар дамжих, эрсдлийн орон зайн олон шалгуурт үнэлгээний аргаар зураглал хийх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтанд тархвар зүйч, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчид хамрагдлаа.

Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөт дархлаажуулалтанд 43256 мал хамруулаад байна. Мал эмнэлэгийн ариун цэвэр, гарал үүслийн бичгийг 2 адуу, 42 хонь, 45.2тн мах, 400ш арьс ширэнд олголоо.

Сумын хэмжээнд малын хашаа 42, бэлчээрийн талбай 49м<sup>2</sup>, нийт 4989м<sup>2</sup> хлор шохойн 2%-ийн 10190 литр уусмалаар 726000 төгрөгийн зардал гаргаж, ариутгал халдваргүйжүүлэлт хийв. Шимэгч дэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээний хүрээнд боловсруулалтанд 13642, туулгалтанд 9122, угаалганд 1631 нийт 24442 малыг хамруулсан.

Сээр багийн ИНХ-аар Сангийн далайн давсны орд газрыг сэргээх, хамгаалах зорилгоор 1 жилийн хугацаанд түр хаасан. Үүнтэй холбогдуулан Сангийн далайн давсны орд газарт байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нар хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар зөрчил илрээгүй болно.

Татварын байцаагчийн ажил үүргийн хуваарийн дагуу бүх аж ахуйн нэгж байгууллагуудад тайлан илгээх хугацаа болон тухайн сард төлөх татварын ноогдолуудыг нэхэмжлэхийн хамтаар хүргүүлж ажиллав.

Аймгийн Засаг даргын А/102 тоот захирамж, сумын Засаг даргын А/33 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулагдан Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн улсын үзлэгийг 06 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус өдрөөр авто тээвэр эзэмшигчдэд автын болон, агаарын бохирдлын нэхэмжлэл үүсгэж, ногдолыг төлүүлэн, гэрчилгээнд бичилт хийлээ.

Тэтгэврийн даатгалын сангаас 2019 оны 06 дугаар сарын байдлаар нийт 382 тэтгэвэр авагчдад 122616,5 мянган төгрөгийн санхүүжилтээр тэтгэвэр бүрэн тавьж олгов. Өндөр насны тэтгэвэр авагч 280, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 33, тахир дутуугийн тэтгэвэр авагч 69 иргэнд олгож ажиллав. Сайн дурын даатгалд 84 даатгуулагчийн 20208,9 мянган төгрөг, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 37132,9 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлээ. Тайлант сард шинээр 5 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгууллаа. Эрүүл мэндийн даатгалд 67 даатгуулагчийн 2419,9 мянган төгрөгийн орлого оруулж ажиллав.

Тэтгэмжийн даатгалын сангаас 5 даатгуулагчдад жирэмсэн амаржсаны тэтгэмжид 6737,6 мянган төгрөг даатгуулагчдад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжид 71,6 мянган төгрөг тус тус олгосон.

НҮБ-ын аж үйлдвэр хөгжлийн байгууллага, ХХААХҮ-ийн яам, Мал эмнэлэгийн ерөнхий газар хамтран “Хонины ноосны чанарыг сайжруулах” сургалтанд хамрагдаж туршлага судалсан. Энэ үеэр 10 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хонь ноос хяргах тоног төхөөрөмжийг Сээр хөгжил хоршооний малчдад гардуулан өглөө.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн зорилго, сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, сургуулийн менежментийн төлөвлөгөөг гаргалаа.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард амбулатороор 184 хүнд үйлчилж, алсын дуудлагад 22 удаа явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллав.

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж эхийг цаг тухайд нь хяналтанд хамруулан онцгой анхаарч ажиллав. Тайлант сард шинээр жирэмсний хяналтанд 8 эхийг авч хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж байна. Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 148 хүн шинжилгээнд хамрагдахаас зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн шинжилгээнд тайлант сард 8 хүнийг хамруулан эрт илрүүлэг 35 хувьтай байна. Шээсний шинжилгээ 54 хүн, ДОХ-ын шинжилгээ 160, элэгний В,С вирусын шинжилгээ 24 хүн, хеликобактер 22, сахар 68, Умайн хүзүүний шинжилгээ 45 хүнийг тус тус хамруулсан. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэдэсний халдварт өвчнөөс сэргийлье” сургалтыг ард иргэдийн дунд зохион байгуулж, 30 хүн хамрагдлаа.



Сургуулийн өмнөх боловсролын хуулийн хэрэгжилтийг хангахын тулд багуудийн тойргийн хүүхдийн судалгаа гаргаж цэцэрлэгт хамрагдаж чадаагүй хүүхдүүдийн шалтгааныг тогтоож 5 настай 21 хүүхдийг тусгай хөтөлбөр боловсруулан бүлгийн сургалт зохион байгуулж хамралтын хувийг 94,2%-д хүргэж ажиллав.

**Цэцэг сум:** Сумын Засаг даргын 2019 оны А/41 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг сумын хэмжээнд нийтийн хоолны үйл ажиллагаа эрхэлж буй 6 нийтийн хоолны газар, 22 хүнсний дэлгүүрт хяналт шалгалт хийж, хугацаа хэтэрсэн 24 төрлийн 727900 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч устгалын комиссоор устгуулав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн 3 сая төгрөгөөр хэсгийн мөрдөгч, цагдаа нарыг драгер төхөөрөмжтэй болголоо.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу Хажинга, Хөшөөт, Баян-гол, Баян-Овоо багт ажлын хэсэг ажиллаж, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 380 гаруй иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэж ажиллав.

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Хажинга багийн Хүрэнгийн 250м гүний худгийг улсын төсвийн 10 сая, Орон нутгийн хөгжлийн сангаас 18 сая төгрөгөөр шинээр худаг гаргав. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 10 айлын хашаа барих, 12 айлын орон сууц, цагдаагийн байрыг нэгдсэн дулаанд холбох ажлыг гэрээний дагуу 30 хувийн мөнгийг гүйцэтгэгч нарт шилжүүлэв.

Сумын Эрүүл мэндийн төв нь “Инээмсэглэл-ээрэг хандлага” уриан дор сумын Засаг даргын ивээл дор эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зохион байгуулж үзлэг шинжилгээнд хамрууллаа. ББОЭТөвийн эмч Б.Анхбаяр урилгаар ирж Эрүүл мэндэд эмэгтэйчүүдийн оролцоо, өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны талаар, Бэлгийн замаар халдварын талаар 400 эмэгтэйчүүдэд сургалт хийв.

Улаанбурхан, Улаануудын нэмэлт дархлаажуулалтын 10 хоногийн аяны хүрээнд явуулын болон түр цэг үйлчилгээгээр 5-18 насны 772 хүүхэд хамрууллаа.

**Булган сум:** Сар бүр удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, төсөвт байгууллагуудын мэдээлэл сонсож тухайн сард хийх ажлын санал авч төлөвлөгөөнд тусган батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант сард орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сум дундын Цагдаагийн хэлтэсээс Сарнай цэцэрлэгийн уулзвар хүртэлх 140 метр бетон зам, явган хүний зам, авто машины нэгдсэн зогсоолийг шинэчлэх ажил, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 450 хүний суудалтай спорт ордоны барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

**Мөст сум:** Сумын ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдаанаар хагас жилийн төсвийн тодотгол, сжмын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт хийсэн ажлын тайлан нийт 5 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Сумын Засаг даргын Тамгын газар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, ил тод хүргэж хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулж, энэ ажлын хүрээнд багуудийн ИНХ-д оролцох, нийт

иргэдийн дунд бүх байгууллагын хагас жилийн ажлын тайланг нээлттэйгээр хэлэлцүүлж тайлагналаа.

Тайлант сард Байгаль орчны чиглэлийн хяналт шалгалт 3 удаа зохион байгуулж, бүх нийтээр мод тарих өдрөөр нийт 150ш мод тариалж сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэв. Нутгийн зөвлөлтэй хамтран хайлаас 100ш, бургас 100ш нийт 350ш модыг сумын баяр наадмын талбайд тариалав. Цаашид ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд анхаарч сумын хөрс клонкоос МАН-ын байр хүртэлх зам дагуух талбайг торлож мод тарихаар ажиллаж байна. Сумын төв, төв суурин газар мал бэлчээхгүй ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс ард иргэдийг урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын төвд нэн ховор ан амьтаны экологи эдийн засгийн үнэлгээг багтаасан гэрэлт самбар хийж байрлуулж олон нийтэд мэдээлж байна. Босоо тэнхлэгийн авто замтай Мөст сумыг холбох замын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй, ажлын явцад байнгын хяналт тавьж байна.

Иргэн гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлүүлэх ажлын талаар жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж ажилласан, хагас жилийн байдлаар 2 иргэнд 0.24 га газрыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлж, 5 иргэн өмчилсөн газрынхаа хэмжээ талбай өөрчлүүлээ.

Сумын мал эмнэлэгийн тасаг малын халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх ажлын хүрээнд тарилга, туулгалт, угаалга боловсруулалт хийх ажлыг хувийн МЭҮН-тэй хамтын гэрээний дагуу хийж гүйцэтгээд байна. Энэ онд халдварт өвчнөөс сэргийлэх захиалагат 9 нэр төрлийн вакциныг сумын МЭТасаг татан авч МЭҮН-үүдэд хуваарийн дагуу олгож одоогийн байдлаар 60800 толгой малд тарьснаас туулгалтанд 47190 толгой мал хамрууллаа.

Мал амьтны халдварт Галзуу өвчин 2 удаа оношлогдож үхэр-3, Бог-3, Үнэг-1, Нохой -3 бүгд 10 мал амьтан өвчилснийг устгаж, малыг галзуу өвчнөөс сэргийлж вакцинжуулалтад нийт 1500 толгой мал хамрууллаа. Малын сэг зэм устгах ажлыг Японы хүүхдийг ивээх сангийн төсөлтэй хамтран хэрэгжүүлж баг бүрт устгалын цэг байгуулан төвлөрсөн зам, өвөлжөө хаваржааны орчмын сэг зэмийг цэвэрлэж устгасны зэрэгцээ Алтай сумын нутаг бага хөндлөнгийн ам, Үенчийн эхэнд 2 газар устгал хийлээ.

Сумын Эрүүл мэндийн төв нь нийт 940 иргэнд үзлэг хийж, 780 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 98 иргэнийг идэвхтэй хяналтанд авч, дуудлагаар 12 иргэнийг үзэж 53 иргэнийг хэвтүүлэн эмчиллээ.